Төв аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтэс

ТӨВ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2019/8

Хүн ам, улсын бүртгэл

Хүн ам

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2019 оны эхний 8 сард төрсөн хүүхэд 1235; нас барсан хүн 357; бусад аймаг хотоос шилжин ирсэн 1363 хүн бүртгэгдлээ. Төрсөн хүүхдийн 101.1, нас барсан хүний 124.1 хувь нь хүн ам, өрхийн мэдээллийн сан(ХАӨМС)-д оруулжээ.
Улсын төсөвт 2019 оны эхний 8 сард 50.5 сая ₮ төвлөрүүлсэн нь 2018 оны мөн үеэс 29.0 хувь буюу 20.5 сая ₮-өөр буурлаа. Орон нутгийн төсөвт 2019 оны эхний 8 сард 28.5 сая ₮ төвлөрүүлсэн нь 2018 оны мөн үеэс 30.1 хувь буюу 12.3 сая ₮-өөр буурлаа.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2019 оны эхний 8 сард нийт 10356 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 332; төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт 4; төрөөс худалдаж авсан газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 5; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 3662; бэлэглэлийн гэрээ 257; худалдах, худалдан авах гэрээ 785; өв залгамжлал 117; барьцааны гэрээ 2464; бусад бүртгэл 2730-ийг тус бүр бүртгүүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2019 оны эхний 8 сард нийт 127 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 83; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 11; гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 5; нөхөрлөл /ЗБН/ 16, /ББН/ 1; хоршоо 2; шашин 4; төсөвт 1; төрийн өмчит үйлдвэрийн улсын газар /ТӨҮУГ/ 2; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 1; банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ 1 тус бүр бүртгүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2019 оны эхний 8 сард 162 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 60; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 3; дүрэм шинэчилсэн 3; дахин гэрчилгээ 30; удирдлага өөрчлөгдсөн 28; үйл ажилгааны чиглэл өөрчлөгдсөн 15; дүрмийн сан нэмэгдсэн хасагдсан 8; хаяг өөрчлөгдсөн 3; нэр хэлбэр өөрчлөгдсөн 5; татан буугдсан 6; салбар бүртгүүлсэн 1 тус бүр бүртгүүллээ.

Нийгмийн даатгал, нийгмийн халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2019 оны 8-р сард НДШ-ийн орлого 13.9 тэрбум.₮ болж төлөвлөгөө 113.3 хувь биелэлээ. Төлөвлөгөөг Архуст сум 11.4 хувиар тасалдуулж 26 сум 6.8-53.6 хувиар давуулан биелүүллээ. Сайн дурын НДШ-ийн орлого 1.5 тэрбум.₮ болж төлөвлөгөө 100.3 хувь биелүүллээ. Төлөвлөгөөг Мөнгөнморьт, Архуст, Зуунмод, Баянчандмань, Баянцогт, Сүмбэр, Аргалант, Заамар, Жаргалант сум 29.0-3.8 хувиар тасалдуулж бусад 18 сум 0.6-28.4 хувиар давуулан биелүүлэв.
Тэтгэвэр, тэтгэмжид 38.3 тэрбум.₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 81.1 хувийг өндөр настны, 10.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.3 хувийг тэжээгчээ алдсаны, 5.5 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.
Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 341956.1 ₮ боллоо.
Нийгмийн даатгалын нийт зарлагын 35.6 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 26.3%; тэтгэмжийн даатгалын сангийн 83.9%; эрүүл мэндийн даатгалын сангийн 113.5%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний

даатгалын сангийн 118.3%; ажилгүйдлийн даатгалын сангийн 60.7%-ийг тус тус бүрдүүлжээ.

2019 оны 8-р сарын эцэст нийгмийн даатгалын сангийн авлага 1.2 тэрбум.₮, өглөг 155.0 сая.₮ боллоо.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2019 оны эхний 8 сарын нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 61068 хүнд олгож, 13.0 тэрбум ₮-ийг зарцуулж 2018 оны мөн үеэс хүний тоо 11.3 хувь 6220 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 11.9 хувь 1.4 тэрбум ₮-өөр тус бүр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 158000₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.4 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 18.6 хувийг халамжийн тэтгэвэр; 8.1 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 6.2 хувийг насны хишгийн зардал; 2.8 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 1.8 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 1.8 нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 0.6 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.



Эрүүл мэнд

2019 оны эхний 8 сард 10466 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.6 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2019 оны эхний 8 сард 736 хүүхэд мэндэлсэн нь 2018 оны мөн үеэс 32 хүүхдээр буурлаа.

Он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 9 хүүхдээр буурлаа.



Эмнэлгийн мэдээгээр 2019 оны эхний 8 сард 317 хүн нас барсан нь 2018 оны мөн үеэс 5.6 хувиар буурлаа. Нас барсан хүний 13.8 хувь буюу 44 нь эмнэлэгт нас баржээ.

Нас баралтыг шалтгаанаар аваад үзвэл хорт хавдарын нас баралт хамгийн өндөр 29.6 хувь, гадны шалтгаан 14.5 хувийг эзлэв.

2019 оны эхний 8 сард халдварт өвчнөөр 494 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 6.9 хувь буюу 32 хүнээр өслөө. Халдварт өвчлөлийг өмнөх онтой харьцуулбал салхин цэцэг 1.5, сүрьеэ 1.1 дахин, тус тус өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 53 байгаа бол: Сүмбэр 281, Дэлгэрхаан 176, Зуунмод 130, Баянчандмань 113 ногдлоо.

10000 хүнд ноогдох халдварт өвчний тоог газрын зургаар харуулвал.

	Интервал-хүнээр	Сумын тоо
	5-16	10
	17-32	7
	33-113	7
	114-281	3
	0	0

_ Сум хилийн зааг



АЖИЛГҮЙЧҮҮД

2019 оны 8 дугаар сард ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 232 болж, 2018 оны мөн үеэс 83 хүнээр, өмнөх сараас 17 хүнээр тус тус буурав.

Ажилгүйчүүдийн 54.3 хувь буюу 126 нь эмэгтэйчүүд юм. 2019 оны эхнээс 548 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 418 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 51.2 хувь буюу 214 нь эмэгтэйчүүд байв. Ажилгүйчүүдийн бүртгэлээс оны эхнээс 1685 иргэн хасагдлаа.

Аймгийн бүртгэлтэй ажилгүйчүүдийн 25.4 хувь нь Зуунмод суманд; 20.7 хувь нь Баяндэлгэр суманд; 12.1 хувь нь Эрдэнэ суманд; 5.2 хувь нь Заамар суманд; 5.2 хувь нь Жаргалант суманд; 4.3 хувь нь Баян-Өнжүүл суманд тус тус бүртгэгджээ.

Тайлант сард бүртгүүлсэн 115 ажилгүй иргэний 38.3 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 20.0 хувь нь шилжин суурьшсан; 4.3 хувь нь орон тооны цомхтголд орсон; 3.5 хувь нь гүйцэтгэж буй албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 1.7 хувь нь цэргээс халагдсан; 1.7 хувь нь байгууллага татан буусан; 30.4 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын түвшингөөр хуваавал 19.4% нь дээд; 3.9% нь тусгай дунд; 9.1% нь мэргэжлийн анхан шатны; 56.9% нь бүрэн дунд; 7.8% нь бүрэн бус дунд; 1.7% нь бага; 1.3% нь боловсролгүй иргэд юм.

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд дунджаар 38 ажилгүйчүүд ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 43 хүнээр бага ногдов. Аймгийн дундажтай сумдын дунджийг харьцуулбал Зуунмод, Сүмбэр, Баян-Өнжүүл, Архуст, Эрдэнэ, Баяндэлгэр сумдад аймгийн дунджаас олон ажилгүйчүүд (53-452 хүн) ногдов.

Тайлант сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд зуучлуулсан 15 иргэний 66.7 хувь нь бүрэн дунд; 26.7 хувь нь дээд; 6.7 хувь нь бүрэн бус дунд боловсролтой иргэд байв.

2019 оны эхнээс байнгын ажлын шинэ байранд 590 иргэн ажилд оржээ. Эдийн засгийн салбарын ангиллаар ангилбал 33.4 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын; 28.0 хувь нь Боловсруулах үйлдвэрлэлийн; 13.1 хувь нь Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээний; 8.1 хувь нь Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын; 4.1 хувь нь Уул уурхай олборлолтын; 2.5 хувь нь Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний; 2.7 хувь нь Боловсролын; 1.9 хувь нь Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны; 1.7 хувь нь Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны; 0.7 хувь нь Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны; 0.5 хувь нь Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны; 0.5 хувь нь Цахилгаан, хий, уур, агааржуулалтын; 0.5 хувь нь Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа; 0.2 хувь нь Урлаг, үзвэр, тоглоом наадмын; 2.0 хувь нь Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбаруудад тус тус ажилд орлоо.

Мөн улирлын ажлын шинэ байранд 124 иргэн, түр ажлын шинэ байранд 51 иргэн ажилд оров.





10000 ХҮН АМД НОГДОХ АЖИЛГҮЙЧҮҮДИЙГ СУМДААР ҮЗҮҮЛБЭЛ:

	Интервал-хүнээр	Сумын тоо
	0-7	7
	8-18	7
	19-35	7
	36-452	6



Төрийн хяналт

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2019 оны эхний 8 сарын мэдээгээр нийт 200 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 210; үүнээс тохирлын гэрчилгээ 160, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 3901; цулын хэмжүүр 528, үүнээс жин 463, туухай 64; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 1703, үүнээс түгээгүүрийн хошуу 198, шингэн бүтээгдэхүүнийг хэмжих хэрэгсэл 22, мерник 13, сүмбэн метр 21, уртын хэмжих хэрэгсэл 4, усны тоолуур 1445, нэг фазын тоолуур 1436, гурван фазын тоолуур 84, гүйдлийн трансформатор 150-ыг тус бүр баталгаажуулаа.

Санхүүгийн хяналт, шалгалт

Санхүүгийн хяналт, аудитын алба 2019 оны эхний 8 сард 94 нэгж байгууллагад хяналт, шалгалт хийж 2.9 тэрбум ₮-ийн зөрчил, төлбөр илэрч төлүүлвэл зохих төлбөрийн барагдуулалт 87.1 сая ₮ болж 30.3 хувийн биелэлтэй гарлаа.



Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2019 оны эхний 8 сард аймгийн хэмжээнд 587 гэмт хэрэг бүртгэгдэж 279 хүн холбогдож, иргэдийн өмчид 2.9 тэрбум ₮-ийн хохирол учирлаа.

Гарсан гэмт хэргийн 39.4 хувь нь хулгай, 24.0 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний эсрэг, 16.0 хувь нь замын осол, 5.8 хувь нь хүний амь, 0.2 хувь нь танхай дээрэм, 14.7 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Эрдэнэ, Аргалант, Лүн, Баян, Өндөрширээт, Баянчандмань, Баян-Өнжүүл, Алтанбулаг сумдад 10000 хүнд 423-96 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (90)-ээс харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2018 оны мөн үеэс 29 хэргээр өслөө.

Зуунмод суманд 29 эмэгтэй, 440 эрэгтэй нийт 469 хүн эрүүлжүүлэгдсэн байна.





Гарсан гэмт хэргийн 22.2 хувь нь бүлгээр 29.7 хувь нь согтуугаар үйлдэгджээ.
Гэмт хэргийн улмаас 218 хүн гэмтэж, 59 хүн нас барлаа.





Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2019 оны эхний 8 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 792 гүйцэтгэх хуудсанд нийт 8.0 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс биелүүлбэл зохих 720 гүйцэтгэх хуудасны 6.3 тэрбум ₮-өөс 311 хуудасны 1.5 тэрбум ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 43.2, үнийн дүнгээр 24.0 хувь болж 2018 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 11.5 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 0.5 нэгжээр тус тус өслөө.



ТӨСӨВ, МӨНГӨ

Төсвийн орлого 2019 оны эхний 8 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 15.3 тэрбум ₮, зарлага 47.5 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 115.0 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас; өмчийн татвар; улсын тэмдэгтийн хураамж, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр; байгалийн ургамал; ус, рашаан ашигласны төлбөр; түрээсийн орлого, хөрөнгө борлуулсны орлого биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2018 оны мөн үеэс 48.3 хувь буюу 5.0 тэрбум ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 87.4 хувийг татварын, 12.0 хувийг татварын бус орлого, 0.6 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2018 оны мөн үеэс татварын орлого 1.5 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 0.2 нэгжээр тус бүр өсч; татварын бус орлого 1.7 нэгжээр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 20.8 тэрбум ₮ болж аймгийнх 12.1 тэрбум ₮ буюу 58.2 хувь; сумынх 3.2 тэрбум ₮ буюу 15.3 хувь; улсынх 5.5 тэрбум ₮ буюу 26.5 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2019 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 40.2 хувь буюу 125.0 сая ₮-өөр өсч 436.0 сая ₮ болж, авлага 1.1 дахин буюу 125.3 сая ₮-өөр буурч 116.9 сая ₮ боллоо.



Орон нутгийн төсвийн орлого 14.7 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 113.1 хувь биелэв. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 3.2 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 128.1 хувь биелэв. Мөнгөнморьт, Зуунмод, Баянцагаан, Баян, Өндөрширээт, Архуст, Баян-Өнжүүл, сумд 41.6-0.4 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлого 12.1 тэрбум ₮ болж төлөвлөгөө 112.0 хувь биелж Сэргэлэн, Баяндэлгэр, Дэлгэрхаан, Баянхангай, Эрдэнэ, Архуст, Угтаал, Сүмбэр, Баян, Баянжаргалан сумд 30.3-0.2 хувиар тасалдууллаа.

Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн банкны салбаруудын дүнгээр 2019 оны эхний 8 сард кассын орлого 321.4 тэрбум ₮, кассын зарлага 319.8 тэрбум ₮ болж, гүйлгээнд 452.6 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 34667, зээлийн багцын дүн 188.9 тэрбум ₮; 2019 онд зээл авсан зээлдэгчийн тоо 60587, олгосон зээлийн дүн 100.5 тэрбум ₮ боллоо.



Иргэдийн хувийн хадгаламжинд 8 сарын 31-ний байдлаар хугацаатай хадгаламж 66.9 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 19.9 тэрбум ₮ байна.

8 сарын 31-ны байдлаар иргэдийн харилцах дансны үлдэгдэл 159516 иргэний 16.0 тэрбум ₮, 1760 байгууллагын 4.8 тэрбум ₮ боллоо.



ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.3-1.5 хувь, хугацаатай доод хүү 0.1-0.7 хувь, хугацаагүй дээд хүү 0.6 хувь, хугацаагүй доод хүү 0.1-0.6 хувьтай байна.

ҮНЭ, ТАРИФ

а. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2019 оны 8 дугаар сард суурь он буюу 2015 оны 12 дугаар сараас 21.4 хувь, өмнөх оны мөн үеэс 6.8 хувь, оны эхнээс 5.0 хувь, өмнөх сараас 0.7 хувиар тус бүр өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 12.8 хувь; боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 11.5 хувь; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ дүнгээрээ 9.2 хувь; эм, тариа, эмнэлгийн

үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Мөн хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.7 хувь; тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 5.2 хувь; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ дүнгээрээ 3.0 хувь; гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ дүнгээрээ 2.9 хувь; орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ дүнгээрээ 0.6 хувь; бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувь; амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.6 хувь; холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувиар тус тус өсөв.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар өссөн ба боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 11.6 хувь; орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ дүнгээрээ 1.1 хувь; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь; хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Мөн бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувиар өсөв. Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувиар буурч бусад 5 бүлгийн үнэ тогтвортой байв.

2019 оны 8 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 238 нэрийн бараа, үйлчилгээний 20.6 хувийнх нь үнэ өсөж, 8.0 хувийнх нь үнэ буурч, 66.0 хувийнх нь үнэ тогтвортой байв.



2019-08/2015-12
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ
99.0
Амралт,чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ
105.0
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш
109.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа
113.8
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис
115.0
Бусад бараа, үйлчилгээ
117.5
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ
119.0
ЕРӨНХИЙ ИНДЕКС
121.4
Тээвэр
122.8
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа
122.8
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ
128.0
Боловсролын үйлчилгээ
130.0
Хувцас, бөс бараа, гутал
136.3
Хувь


2019-08/2018-08
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ
100.2
Амралт,чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ
101.6
Бусад бараа, үйлчилгээ
102.5
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш
102.9
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа
102.9
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис
103.0
Тээвэр
105.2
Хувцас, бөс бараа, гутал
106.7
ЕРӨНХИЙ ИНДЕКС
106.8
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ
108.4
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ
109.2
Боловсролын үйлчилгээ
111.5
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа
112.8
Хувь


2019-08/2018-12
Тээвэр 99.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 100.0
Амралт,чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 100.1
Бусад бараа, үйлчилгээ 101.9
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 102.5
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 103.0
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 104.6
Хувцас, бөс бараа, гутал 104.9
ЕРӨНХИЙ ИНДЕКС 105.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ 106.5
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 109.2
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа 111.5
Боловсролын үйлчилгээ 111.5


2019-08/2019-07
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа 99.2
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 100.0
Амралт,чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ 100.0
Тээвэр 100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 100.0
Бусад бараа, үйлчилгээ 100.6
ЕРӨНХИЙ ИНДЕКС 100.7
Хувцас, бөс бараа, гутал 100.8
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 100.8
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 101.1
Боловсролын үйлчилгээ 111.6
Хувь

б. Хөдөөд 2019 оны 8 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф суурь он буюу 2015 оны 12 сартай харьцуулахад 17.8%, өмнөх оны мөн үе буюу 2018 оны 7-р сартай харьцуулахад 6.2%-аар тус тус өсч, өмнөх сартай харьцуулахад 0.7%-аар буурав.

Хөдөө аж ахуй

Ургац хураалт

09 сарын 01-ний байдлаар төмс 3353.5 тонн, хүнсний ногоо 491.5 тонн хурааж авлаа. Урьд оны мөн үеэс төмс 45.4 тонноор, хүнсний ногоо 362.2 тонноор тус бүр өслөө.





09 сарын 01-ний байдлаар 960.0 тонн өвс, 4.6 тонн гар тэжээл бэлтгэв.

АЖ ҮЙЛДВЭР

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2019 оны эхний 8 сард (2010 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 55.5 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2018 оны мөн үеэс 1.6 хувь буюу 0.8 тэрбум ₮-өөр өслөө.

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт 1.7 хувь буюу 0.8 тэрбум ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Жаргалант, Баянчандмань, Зуунмод сумд 39.3-6.4 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 90.6) хувийг эзлэв.

2019 онд нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 4.9, боловсруулах үйлдвэрлэл 9.7, ашигт малтмал олборлолт 85.4 хувийг тус тус эзлэв.



Оны эхний 8 сард аж үйлдвэрийн гол нэр төрлийн 27 бүтээгдэхүүнээс 18 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өнгөрсөн оноос нэмэгдлээ. Нэр төрлөөр нь үзвэл: шохой, монгол дээл, савхин гутал, монгол гутал, хэрчсэн гурил, ундаа рашаан, зүсмэл материал, польто, хөвөнтэй бээлий, угаасан ноос, бяслаг, бланк, шингэн сүү зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, алт, куртка, өмд, цамц желет, төмрийн хүдэр, талх, төмөр эдлэл, түгээсэн цэвэр ус, сувагжуулалт, бууз, арвайн гурил, нарийн боов, ажлын хувцас, спорт хослол, гэрийн модон эдлэл, хүснэгт маягт, угаасан ноос, шохойн чулуу, эмэгтэй хослол, жонш, ногооны консерв, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурав.

Аж үйлдвэрийн салбарын дүнгээр 2019 оны эхний 8 сард оны үнээр 78.2 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн борлуулсан нь 2018 оноос 0.3 хувь буюу буюу 2.3 тэрбум ₮-аар өслөө.

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Жаргалант, Баянчандмань, Зуунмод сумд 39.3-6.4 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 90.6) хувийг эзлэв.

2019 онд нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 4.9, боловсруулах үйлдвэрлэл 9.7, ашигт малтмал олборлолт 85.4 хувийг тус тус эзлэв.

АУ-ийн бүтээгдэхүүний борлуулалтыг газрын зургаар харуулбал

	Интервал-сая төг	Сумын тоо
	1.0-18.7	7
	18.8-73.6	7
	73.7-1429.4	7
	1429.5-30709.8	6
	0	

Аймаг, сумын хилийн заг



Аж үйлдвэрийн салбарт оны эхний 8 сард нийт 1549 хүн ажиллаж бүтээмж 35.7 сая ₮ байгаа нь 2018 оноос 1.1 хувиар, 2017 оноос 0.4 хувиар тус тус өслөө.

Ахуй үйлчилгээний байгууллагууд оны эхний 8 сард 823 цэгт 1126 хүн ажиллаж 2.5 тэрбум ₮-ийн орлого үйлчилгээний ажил хийж 1.3 тэрбум ₮-ийн зардал гаргаж 185231 хүнд үйлчилжээ. Нийт орлогын 15.1 хувь нь оёдол, 11.2 хувь нь гутал, 4.9 хувь нь модон эдлэл, 43.9 хувь нь тээврийн хэрэгслийн болон ахуйн техникийн засвар, 12.9 хувь нь үсчин гоо засал, гэрэл зураг, 4.1 хувь нь халуун усны, 7.5 хувь нь бусад үйлчилгээний орлого эзлэв.

БАРИЛГА

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2018 оны эхний 8 сард 6.4 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь 2017 оны мөн үетэй харьцуулахад 26.7 хувиар буюу 1.6 тэрбум ₮-өөр өслөө.

Барилга угсралт, их засварын ажлын 26.0 хувь нь орон сууцны барилгад; 42.0 хувь нь орон сууцны бус барилгад; 32.0 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдсон нь 2017 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны барилгын ажил 12.0 пунктээр, орон сууцны бус барилгын ажил 2.1 пунктээр тус бүр өсч, инженерийн барилга байгууламжийн ажил 14.1 пунктээр буурлаа.



Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 8 сард 160.0 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 37.3 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.2 хувь буюу 8.6 сая ₮-өөр буурлаа.



Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 85.5 сая ₮ болсон ба нийт орлогын 80.0 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 20.3 хувийг албан бичгийн 6.3 хувийг зорчигчдын, 73.4 хувийг бусад орлого бүрдүүллээ.

Статистикийн хэлтэс